| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 21,000.00 | 21,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 497,000.00 | 497,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 188,000.00 | 188,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 168,100.00 | 168,100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 540,000.00 | 540,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 461,300.00 | 461,300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,071,500.00 | 2,071,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,071,500.00 | 2,071,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |

| | | | |
|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 301,815,500.00 | 301,815,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 301,815,500.00 | 301,815,500.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 301,815,500.00 | 301,815,500.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | - | 28.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 19.00 | 19.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **19.00** | **19.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 10.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9.00 | 9.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **3,500,000.00** | **18,286,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,500,000.00** | **18,286,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,500,000.00 | 15,409,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,300,000.00 | 3,300,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 336,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,300,000.00 | 2,684,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 280,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 2,420,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | |
| 210604 | Урсгал засвар | - | 2,420,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 2,336,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 2,336,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 1,853,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 1,853,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,200,000.00 | 5,500,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,200,000.00 | 5,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 2,877,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **2,877,000.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,877,000.00 |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,500,000.00 | 18,286,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,500,000.00 | 18,286,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500,000.00 | 3,053,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 6,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,000,000.00 | 9,233,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |

| | | | |
|---|---|---|---|
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Баян-Өлгий аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь нь орон нутаг дахь мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мал сүргийг үзлэг ангилалт, хянан баталгаанд хамруулах, бэлчээрийн болзошгүй эрсдэлээс мал сүргийг хамгаалах, хүнс, газар тариалан, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хоршоо, биржийг хөгжүүлэх бодлого, зорилт, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн түвшинд хангах, зохицуулах, удирдан зохион байгуулах, бодлого, төлөвлөлтийн төсөл, төсвийн төсөөлөлд хариуцсан чиглэлээр санал боловсруулах, төсвийг оновчтой зарцуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, холбогдсон чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг мэргэжил, арга зүйгээр болон нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээгээр хангах, төрийн шуурхай үйлчилгээг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2022 онд “Дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх чадвартай, байгалийн болон эдийн засгийн эрсдэл даах эрчимжсэн хөдөө аж ахуй, өндөр технологи бүхий хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарыг төлөвшүүлэх” зорилго тавин ажиллаж байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:
1. Удирдлагын орчин үеийн арга туршлага нэвтрүүлэх, үндэсний технологи хөгжүүлэх, шинжлэх ухааны ололт, шинэ бүтээл үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээдийг дэмжиж, аж ахуйн нэгж, фермер, малчин өрхийн менежментийг сайжруулж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

3. хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн даац нэмэгдүүлэх, газар тариалан, бэлчээрийг усаар хангах арга хэмжээг өргөжүүлэх, уст цэгийн ашиглалт, эзэмшлийг сайжруулах;

4. мал сүргийн чанарыг сайжруулж, удмын санг хамгаалахын зэрэгцээ мал сүргийг байгалийн гамшгаас сэргийлэх, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх;

5. мал, амьтны халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх замаар өвчний тархалт, гаралтыг тогтвортой бууруулах;

6. хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх санаачилга хөдөлгөөнийг өрнүүлж ядуурлыг бууруулах, малчдын хөдөлмөрийг хорших, ажлын байр бий болгох, үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр хоршоо байгуулахад тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлэх;

7. дэлхийн тэргүүний техник технологийг нутагшуулах үйл ажиллагааг дэмжих замаар экспортын баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;

8. орон нутгийн зээлийн чадавхийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн менежментийг сайжруулан, хүний нөөцийн манлайллыг хангах.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Хүнс хөдөө аж ахуйн газар нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль, Малын индексжүүлэлт, даатгалын тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Органик хүнсний тухай хууль, Тариалангийн тухай хууль, Таримал ургамлын үр сортын тухай хууль,

Ургамал хамгааллын тухай хууль, Хоршооны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын 2022 оны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохих журмын дагуу хөтлөж, анхан шатны баримт материалыг зохих журмын дагуу бүрдүүлж, бараа материалын тайланг холбогдох хууль журмын дагуу гаргаж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2021, 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй *гэж* үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Хүнс хөдөө аж ахуйн газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 11 сарын 22-ны өдрийн А/359 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрддөг байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1283.1 сая төгрөгөөр буюу 187 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | 7200.0 | - | -7200.0 |
| Бараа материал | 25,012.1 | 20,627.3 | -4,384.8 |
| Үндсэн хөрөнгө | 653,225.6 | 1,948,009.4 | 1,294,783.8 |
| **Нийт хөрөнгө** | **685,437.7** | **1,968,636.7** | **1,283,199.0** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 685,437.7 | 1,968,636.7 | 1,2831,99.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **685,437.7** | **1,968,636.7** | **1,2831,99.0** |

Дээрх хүснэгтээс харахад бараа, материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгөд үлдэгдэл байхгүй, авлагын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна. Урьчилж төлсөн зардлаар бүртгэсэн 7.2 сая төгрөгийг ХХААХҮЯ-ны санхүү хөрөнгө оруулалтын газраас өгсөн чиглэлээр тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Бараа материалын үлдэгдэл өнгөрсөн оны үлдэгдлээс 4.4 сая төгрөгөөр буурсан байна.Тайлант онд 16.1 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, үнэ төлбөргүй 18.2 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 38.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 20.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Тайлант онд бараа материалын бүртгэлд байсан уулын бор ямааны сүргээс 1.6 сая төгрөгийн ямаа зүй бусаар хорогдож, газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар 4.4 сая төгрөгийн бор ямааг зах зээлийн үнээр 2.7 сая төгрөгөөр худалдан борлуулж, орлогыг нэмэлт дансанд оруулсан байна.

Үндсэн хөрөнгө 1294.8 сая төгрөгөөр өссөн байна.Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдаж аваагүй, үнэ төлбөргүй буюу шилжүүлгээр 16.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 1310.9 сая төгрөгийн дуусаагүй барилгыг дансанд бүртгэж, 17.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, үндсэн хөрөнгөд 30.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Тайлант онд үр дүнгийн тайланд хөрөнгийн орлого хэсэгт дуусаагүй барилга байгууламжийг орлого авч бүртгэсэнтэй холбоотой 1283.2 сая төгрөгийн үр дүнтэй гарч, Засгийн газрын хувь оролцоо данс 1283.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 392.2 сая, нийт зарлагыг 393.2 сая төгрөгөөр төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 90.4 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг нийт дүнгээр 98.2 сая төгрөгөөр бууруулан, цалин, НДШ-ийн зардлыг 7.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 301.8 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 301.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 301.8 сая төгрөг буюу 100.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа | 300.2 | 300.2 | 0 | 100.0 % |
| 2 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 1.6 | 1.6 | 0 | 100.0% |
| | **Дүн** | **301.8** | **301.8** | **0.0** | **100.0%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь тайлант онд 18.3 сая төгрөгийн нэмэлт төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.Үүнд: Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 3.1 сая төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 6.0 сая төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 9.2 сая төгрөгийн орлогыг оруулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 2.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 15.4 сая төгрөгийг зарцуулсан дүнтэй байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Хүнс хөдөө аж ахуйн газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 13 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 401.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 359.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр байсан ба гүйцэтгэлийн шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан тушаал шийдвэрүүдийг тухай бүр хавсаргасан байна.Тайлант хугацаанд 5.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий 12 сарын мэдээлэл нь хугацаанаас хоцорсон мэт харагдаж байгаа боловч харьяа дээд байгууллагаас холбогдох мэдээллийг засуулсан гэсэн тайлбар өгсөн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр хийсэн. Завсрын аудитаар зөрчил дутагдал гараагүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитын дүнгээр 2 заалт бүхий 198.0 сая төгрөгийн зөрчлийг арилган ажиллахаар зөвлөмж өгөгдсөн байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | | | |
| Албан шаардлага | 0 | 0 | | | |
| Зөвлөмж | 1 | 198000.0 | 1 | 198000.0 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **198000.0** | **1** | **198000.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байгаа болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой залруулсан алдаа гараагүй.

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн зөрчил[1] илэрснээс, төлбөрийн акт тавигдаагүй, албан шаардлага өгөгдөөгүй, 0.5 сая төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

*1.1 Илрүүлэлт*: Оны эцэст цалингийн зардлаас 490.7 мянган төгрөгийг дундын санд шилжүүлж, 392.9 мянган төгрөгийг цахилгааны зардалд, 48.8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд холбогдох газрын зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулсан. Ээлжийн амралтын цалинг гаргахдаа “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын дагуу тооцож олгоогүй, ажилласан цагийн бүртгэлийг үнэн бодитоор хөтөлж баримтжуулаагүй байна.

*1.2.Өгсөн зөвлөмж*: Зардал хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох байгууллагын зөвшөөрлийг авах, ажилчдын ээлжийн амралтын цалинг холбогдох журмын дагуу бодож олгох, ажилласан цагийн бүртгэлийг үнэн зөв хөтөлж баримтжуулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |
| **Дүн** | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингийн зардлаас холбогдох зөвшөөрөл авалгүйгээр бусад зардалд гүйлгэн зарцуулсан, ажилчдын ээлжийн амралтыг журмын дагуу тооцож олгоогүй, цагийн бүртгэлийг зөрүүтэй хөтөлсөн | 3 | 490.7 | | | | | 3 | 490.7 | | | | |
| **Дүн** | **3** | **490.7** | | | | | **3** | **490.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | 0 | 0 | | | | | 0 | 0 |
| **Дүн** | 0 | 0 | | | | | 0 | 0 |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | 0 | | | | | | 0 | |
| | 0 | | | | | | 0 | |
| Дүн | 0 | | | | | | 0 | |
| **Нийт дүн** | 0 | 0 | | | | | 0 | 0 |